62

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 02 дугаар сарын 04-ны өдөр | Дугаар А/37 | Багануур

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, "Баганууурын Дулааны станц" ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Баганууурын Дулааны станц" ТӨХК-ийн Ахмадын харъяалалд бүртгэх журам-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх журмыг 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга (Ч.Ариунбаатар)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ГАНБААТАР

Тушаал 2018

"Багануурын Дулааны станц" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2019 оны ..12.. сарын
..04.. өдрийн 137 тоот тушаалын хавсралт

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН АХМАДЫН ХАРЪЯАЛАЛД БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Тус компанид ажиллаж байсан ба ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь татан буугдсан буюу өөр орон нутгаас шилжин ирсэн ахмад настныг бүртгэх, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулахад оршино.

Хоёр. Ахмад настныг бүртгэх

2.1 Дараах шаардлагыг хангасан ахмад настныг бүртгэнэ.

2.1.1 Тэтгэврийн насанд хүрч, тэтгэвэр тогтоолгосон байх:

2.1.2 Өөр аж ахуйн нэгж, байгууллагад ахмадын бүртгэлгүй байх:

2.1.3 Эрчим хүчний салбарт 15 жил, тус компанид 10 жил ажилласан байх:

2.1.4 Тус компанид ажиллаж байсан бол сахилгын арга хэмжээгээр халагдаагүй байх:

2.1.5 Багануур дүүрэгт оршин суудаг байх:

2.2 Шаардлага хангасан өргөдөл, хүсэлтийг хүлээн авсанаас хойш 15 хоногийн дотор Захирлын зөвлөлийн хуралд танилцуулна.

2.3 Ахмад настныг бүртгэн авах эсэхийг Захирлын зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.4 Дээрх шаардлагыг хангасан ахмад настан нь ахмадын харъяалалд бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

2.4.1 Өргөдөл

2.4.2 Иргэний үнэмлэхийн хуулбар

2.4.3 Шаардлагатай тохиолдолд төр захиргааны байгууллагаас уламжилсан албан бичиг

Гурав. Бүртгэлээс хасах

3.1 Дараахь тохиолдолд ахмадыг бүртгэлээс хасна.

3.1.1 Ахмад настан өөрөө хүсэлт гаргасан бол:

3.1.2 Өөр аж ахуйн нэгж, байгууллагад давхар бүртгүүлсэн бол:

3.1.3 Ахмад настан таалал төгссөн бол:

Дөрөв. Бусад

4.1 Энэ журмаар зохицуулагдаагүй харилцааг холбогдох хууль, дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.